

Тоглох Яагаад Чухал вэ

Тоглох хүн бүрт тустай: нялх хүүхдүүд, өсөж буй хүүхдүүд мөн насанд хүрсэн хүмүүс.

Хамтдаа хөгжилдөнө гэдэг амьдралд чухал зүйл. Гэхдээ тоглоом зөвхөн хөгжилдөх тухай биш юм. Жаахан хүүхэд том хүний царайг харж, дууг сонсох үедээ түүнээс суралцаж байдаг.

Тоглох үедээ бид юуг сурдаг вэ:

Таниж мэдэх

Анхаарах

Төвлөрөх

Анхаарал хандуулах

Хэн нэгнийг даган дуурайх

Шинэ зүйлс туршиж үзэх

Нэг зүйлээ хэдэн зуун удаа давтах

Өөрийн мэдрэмжийг ойлгох

Өөр хүнтэй танилцах

Өөрсдийн хийж чадах зүйлсийг олж илрүүлэх

Ээлжилж хийх

Жүжиглэх

Хүлээх

Төсөөлөх

...

Тайван байж хамт хөгжилдөх нь хүүхдүүд эрүүл аюулгүй өсөж торниход тустай байдаг. Энэ эцэг эх болон асран хамгаалагч нарт ч тустай: хамтдаа тоглох нь хамтдаа өсөж байна л гэсэн үг!

Өөр өөр нас – өөр төрлийн тоглоомууд

Том хүний хөмсгөө өргөх эсвэл хэлээ хөдөлгөх үйлдлийг дагаж тоглох нь бага насны хүүхдүүдэд тохиромжтой бөгөөд зугаатай.

“Цэцэрлэгийг тойроод” гэх мэт гижигдэх тоглоомууд өсөж буй хүүхдүүдэд илүү сонирхолтой. Хүүхэд тань харцаа бууруулах эсвэл инээхээ болихыг нь анзаараарай – дараагийн тойрог эхлэхээс өмнө тэдэнд амралт хэрэгтэй байж магадгүй шүү.

“Нуугдаж тоглох” тоглоом нь хүүхдэд хүн ирэх эсвэл явах үед сэтгэл хөдлөлөө хянах чадварыг суулгаж байдаг... Тун удахгүй тэд таниас ямар нэгэн зүйл нууж таны хэрхэхийг харах гээд догдлон сууж байх вий.

Хүүхдүүд цүнх эсвэл шүүгээнүүдийг хоослох маш дуртай – үүнийг тоглоом болгоод “Гадна ба Дотор” гэж тоглон хөгжилдөөрэй.

Та хүүхэддээ бага багаар цөөхөн тоглоомууд өгч тоглуулснаар аюулгүй нөхцөлд түүнийхээ сониуч занг өдөөж, шинэ нээлтээ хэрхэж байгааг нь харж болно.

Баримлын шавар, элс, будаг эсвэл цавуугаар тоглох тодорхой орон зай гаргаж өгснөөр хүүхэд шинэ зүйл туршиж үзэхдээ итгэлтэй болдог.

Усанд орох цаг бол хүүхдийн хувьд усны тухай ойлгож, хаашаа явдгийг нь мэдэж авах тохиромжтой үе.

Үг холбож тоглох болон дуу дуулах нь хүүхдийн хэлний өсөлтөд сайнаар нөлөөлж байдаг.

Хүүхэлдэйгээр эсвэл жижиг амьтадтай тоглохдоо хүүхэд шинэ санаа хэрэгжүүлж, мэдрэмжийн тухай ярьж сурч байдаг.

Watch me play! -д зориулсан 7 зөвлөгөө

- Хүүхдийнхээ тоглохыг хар- тэднээс шинэ санаа олох болно
- Тогтмол “тоглоомын онцгой цаг”-тай бол – хүүхдээрээ ахлуулах ба танийг урихыг хүлээх
- Хүүхдийн тань төсөөлөн бодох чадварыг хөгжүүлэх энгийн тоглоом тоглох
- Зурагт эсвэл компьютергүй чимээгүй орчинг тоглоход зориулж бэлдэх
- Хамт дуу дуулж өөр зүйл хийхэд нь туслах
- Хүүхдийнхээ зурсан зургийг тусгай хавтсанд хийж хадгалах
- Хэрэв хамт тоглох танд хэцүү байвал гэр бүлийнхээ өөр том хүнтэй ярилцах

© 2014 Jenifer Wakelyn